



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/92.

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжих Дархан сумын төвлөрсөн халаалтын системийн ажлын зураг төсөв боловсруулах, Тэмүүжин хаус хорооллын гадна холбоо, цахилгааны ажлын зураг төсөв боловсруулах, Тэмүүжин хаус хорооллын гадна бохирын шугамыг төвийн системд холбох, насос станцын ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Дарга:	Ц.Дэмбэрэлсайхан	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	-Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Бат-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Ж.Даваасүрэн	-ТББ-н төлөөлөл
	Т.Эрдэнэбаатар	-ТББ-н төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА